*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралт*

# ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХАРИУЦСАН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН БЯМБАДОРЖИЙН НАРАНТУЯАГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **ДЗДҮАХ-ийн зорилт 2.3. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах хяналтыг сайжруулах, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах зорилтыг дэмжин хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| **Зорилт 1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнах, хяналт тавих хүрээнд** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг тогтоож, журам батлах тухай” 09 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллана. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 4 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 18 иргэнд 17.5 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. | 2 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | 2 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | 01 | 12 |
| 2. | **Арга хэмжээ 1.2** Хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуйг кластер хэлбэрээр хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 удаагийн арга хэмжээ, 200 өрхөд хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлж, тариалалтыг дэмжин, 2496.4тн ургац хураан авч, хүлэмжийн тариалалт 2.7га талбайгаар нэмэгдсэн. | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | 1 арга хэмжээ зохион байгуулсан байна. | 01 | 12 |
| 3. | **Арга хэмжээ 1.3** Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан, олон улсын | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | - | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | 08 | 11 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллага, төрийн бус байгууллагуудын санал санаачилгыг дэмжин "Ногоон хүнс-Эрүүл амьдрал" арга хэмжээг зохион байгуулна. | | | | | | |
| 4. | **Арга хэмжээ 1.4.** Дүүргийн нутаг дэвсгэрт хүнсний ногоо тариалж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад "Ургамал. ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд гарал, үүслийн гэрчилгээ" олгох, хяналт тавих ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ олгосон тариаланчдын тоо. | 24 газар тариалан эрхлэгчийн 25 нэр төрлийн 111.8тн төмс, хүнсний ногоонд цахим гарал үүслийн гэрчилгээ олгосон. | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 20-оос доошгүй газар тариалан эрхлэгчдэд гарал үүслийн гэрчилгээ олгосон байна. | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 15-аас доошгүй газар тариалан эрхлэгчдэд гарал үүслийн гэрчилгээ олгосон байна. | 02 | 12 |
| 5. | **Арга хэмжээ 1.5.** Дүүргийн нутаг дэвсгэр дэх хээлтэгч, хээлтүүлэгч малыг үзлэг ангилалтад хамруулах, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 2 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | 08 | 10 |
| 6. | **Арга хэмжээ 1.7.** Малын нөхөн үйлдвэрлэл, үржил, селекцийг сайжруулж, эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 19 өрхийн 76 үхэрт зохиомол хээлтүүлэг хийгдсэн. | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | 02 | 12 |
| **Зорилт 2. Хүнсний аюулгүй байдлыг хангах, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах хүрээнд** | | | | | | | |
| 7. | **Арга хэмжээ 2.1.** Газар тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор төмс, хүнсний ногооны худалдаа зохион байгуулж ажиллана. | Худалдаа зохион байгуулсан байршлын тоо, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ | 5 байршилд 30 газар тариалан эрхлэгчийн 97.2тн төмс, хүнсний ногоог худалдан борлуулж, 143.3сая төгрөгийн борлуулалт хийхэд дэмжлэг үзүүлсэн. | - | 3-4 байршилд худалдаа гаргаж, борлуулалтыг дэмжин ажилласан байна. | 08 | 11 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | **Арга хэмжээ 2.2.** Малчин, мал бүхий иргэдийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангуулах ажлыг зохион байгуулж, дүүргийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Мал бүхий 12,13,14 дүгээр хорооны давхардсан тоогоор 1460 өрхөд 237.тн өвс, 66.9тн хивэг, 65тн улаан буудайн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсан. | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | 02 | 12 |
| 9. | **Арга хэмжээ 2.3** Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувь | Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 11 удаагийн дархлаажуулалтад давхардсан тоогоор 364,021 мал, амьтныг хамруулж, хяналт тавьж ажилласан. | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна | 01 | 12 |
| 10. | **Арга хэмжээ 2.4.** Мал амьтны гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын шилжилт хөдөлгөөнийг хянах ажлын хүрээнд малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн баяжилтыг хийж, хяналт тавих ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, цахим системд бүртгэгдсэн мал,амьтны тоо | 2023 оны мал, тэжээвэр амьтны тооллогоор тоологдсон 781 өрхийн 46919 мал, 631 төл, эүй бусаар хорогдсон 2050 мал, амьтныг мэдээллийн санд бүртгэсэн. | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 2024 оны мал тооллоор тоологдсон 49463 малыг цахим системд бүртгэн баталгаажуулсан байна. | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | 01 | 12 |
| 11. | **Арга хэмжээ 2.5** Мал амьтны хашаа хороо, бэлчээрийн ариутгалыг хийх, сэг зэм устгах ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3389 ширхэг мал, амьтны сэг зэмийг устгаж, 12000м2 талбай, 11000м2 талбай бүхий хашаа хороонд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | - | 04 | 07 |
| **Зорилт 3. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд** | | | | | | | |
| 12. | **Арга хэмжээ 3.1.** Цахим болон цаасан баримт бичгийг хүлээн авах, хуулийн хугацаанд шийдвэрлэх, албан хэрэг | Албан бичгийн тоо, шийдвэрлэлтийн хувь | Дээд газар болон бусад байгууллагаас ирүүлсэн 183 албан бичгийг хүлээн авч | 100% | 100% | 01 | 12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтлөлтийн талаарх бодлого стандарт журмыг хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах. | | 100% шийдвэрлэж, холбогдох хэлтэс албадад 106 албан бичиг боловсруулан хүргүүлсэн. | | | | |
| 13. | **Арга хэмжээ 3.2.** Иргэд, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээллийг судлан, хуулийн дагуу шийдвэрлэн хариу өгөх. | Өргөдөл гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь | Иргэдээс ирсэн 38 өргөдлийг хүлээн авч 100% шийдвэрлэсэн. | 100% | 100% | 01 | 12 |
| 14. | **Арга хэмжээ 3.4.** Баримт бичгийг албан бичгийн стандартын дагуу зохион бүрдүүлэх, архивын стандартад нийцүүлэн байгууллагын архивд хадгаламжийн нэгжийг хүлээлгэн өгөх. | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хүлээлгэн өгсөн баримтын тоо | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан 2 хадгаламжийн нэгжийг хүлээлгэн өгсөн. | 2-оос доошгүй хадгаламжийн нэгж үүсгэн, архивчид хүлээлгэн өгсөн байна. | - | 02 | 03 |
| 15. | **Арга хэмжээ 3.4.** Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор баталсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ баримт бичгийн 2.8.2-т харилцаа, хандлага, хувцаслалт, биеэ авч явах байдал, ажлын арга барил, үг, үйлдлээрээ бусдад зөв үлгэрлэн, манлайлах. | Зөрчилтэй ажилласан эсэх | - | Харилцаа, хандлага, хувцаслалт, биеэ авч явах байдал, ажлын арга барил, үг, үйлдлээрээ бусдад зөв үлгэрлэн, манлайлж зөрчилгүй ажилласан байна. | Харилцаа, хандлага, хувцаслалт, биеэ авч явах байдал, ажлын арга барил, үг, үйлдлээрээ бусдад зөв үлгэрлэн, манлайлж, зөрчилгүй ажилласан байна. | 01 | 12 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан мэргэшүүлэх багц сургалтад хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо | Дээд шатны болон Тамгын газраас зохион байгуулсан 9 удаагийн сургалт, семинарт хамрагдсан | 4 | 4 | 01 | 12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | **Арга хэмжээ 2.** Төрийн албаны тухай хуулийн 29.1-д заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдана. | Ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байна. | - | 1 | - | 02 | 06 |

**ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХАРИУЦСАН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ........................................ / Б.НАРАНТУЯА/ 2025.01.15

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА ........................................ / П.САРУУЛТУЯА / 2025.01.15

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

1117137595
0120 35

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН БЯМБАДОРЖИЙН НАРАНТУЯАГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **ДЗДҮАХ-ийн зорилт 2.3. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах хяналтыг сайжруулах, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах зорилтыг дэмжин хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| **Зорилт 1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнах, хяналт тавих хүрээнд** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг тогтоож, журам батлах тухай” 09 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллана. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 4 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 18 иргэнд 17.5 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. | 2 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 5 удаагийн нэгдсэн арга хамжээ зохион байгуулж, 34.6 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан. Үүнд:<br>- Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны “Мал аж ахуй эрхлэх хориглосон бүсэд хяналт тавих ажлын хэсэг байгуулах тухай” А/500 дугаар захирамжаар ажлын хэсгийг шинэчлэн баталж, 13 заалт бүхий ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжилтийн зохион байгуулж ажилласан.Хориглосон бүсэд нэвтэрсэн малыг гаргах ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлэх чиглэлээр 2 | 2025.01.02-2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилтанг тогтмол ажиллуулж, 10 иргэнийг түр ажилтнаар ажиллуулж өдөр тутмын хяналтыг тавьж ажиллаж байна.<br>- Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс 1495 толгой мал гаргаж, давхардсан 748 адуург хашаалж, 20 иргэнд тус бүр зөрчлийн тухай хуулиар тус 1 сая төгрөг нийт 20 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээг Цагдаагийн байгууллагаас авч ажилласан.<br>- Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд малаа нэвтрүүлэхгүй байж, зөвшөөрсөн бүсэд малыг байнгын хариулгатай байлгах талаар дүүргийн менежерийн 2025 оны "Мэдэгдэл хүргүүлэх тухай" 02/39 дугаар албан бичгийг 400 малчин, мал бүхий иргэдэд хүргүүлэн ажилласан. | - | |
| 2. | **Арга хэмжээ 1.2**<br>Хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуйг кластер хэлбэрээр хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 удаагийн арга хэмжээ, 200 өрхөд хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлж, тариалалтыг дэмжин, 2496.4тн ургац хураан авч, хүлэмжийн тариалалт | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | Хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуйг кластер хэлбэрээр хөгжүүлэх зорилгоор 3 удаагийн арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Үүнд:<br>- Дүүргийн 13,14 дүгээр хорооны өрхийн тариалан эрхлэх сонирхолтой 180 өрхөд хөрс, боловсруулалт, тариалалт, арчилгааны талаар сургалт зохион байгуулж, 29 төрлийн хүнсний ногооны үрийг олгон дэмжлэг үзүүлсэн. Мөн нарийн ногооны үрслэг бойжуулах арга, технологи, хөрс боловсруулах, таримал ургамлын өвчин, түүнтэй тэмцэх талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, 80 өрхөд 9 төрлийн | 2025.01.02-2025.11.20 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2.7га талбайгаар нэмэгдсэн. | | хүнсний ногооны үр үрслэгээний дэмжлэг үзүүлсэн.<br>- Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран "MON-SHEP" төслийг 13 дугаар хороонд хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн хүрээнд "Тариад зарах" бус "Зарахын тулд тарих" арга барилд сургах сургалтыг зохион байгуулж ажилласан. | | |
| 3. | **Арга хэмжээ 1.3**<br>Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудын санал санаачилгыг дэмжин "Ногоон хүнс-Эрүүл амьдрал" арга хэмжээг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | - | Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах зорилгоор дүүргийн гэр хороолол бүхий 16 хорооны өрхийн тариалан эрхлэгч 80 иргэнд нарийн ногооны үрслэг бойжуулах арга, технологи, хөрс боловсруулах, ургамал хамгааллын цогц аргыг танилцуулах "Ногоон хүнс-Эрүүл амьдрал" арга хэмжээг хүлэмжийн тариалан эрхлэгч "Амар кейтеринг" ХХК-тай хамтран зохион байгуулж, 9 төрлийн төмс, хүнсний ногоо, гүзээлзгэнэ болон хүлэмжийн ногооны үр, үрслэгээний дэмжлэг үзүүлсэн. | 2025.06.16 | 97% |
| 4. | **Арга хэмжээ 1.4.**<br>Дүүргийн нутаг дэвсгэрт хүнсний ногоо тариалж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад "Ургамал. ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд гарал, үүслийн гэрчилгээ" олгох, хяналт тавих | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэх | 24 газар тариалан эрхлэгчийн 25 нэр төрлийн 111.8тн төмс, хүнсний ногоонд цахим | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 20-оос доошгүй газар тариалан эрхлэгчдэд гарал үүслийн гэрчилгээ | Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам"-ын хэрэгжилтийг хангах ажлын чиглэлээр:<br>- Газар тариалан эрхлэгчдийг "Газар тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем"-ийн программ ашиглалтын талаарх сургалтыг 2 удаа зохион байгуулж, холбогдох мэдээ мэдээлэл өгч ажилласан. | 2025.01.02-2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулна. | үүний гарал үүслийн гэрчилгээ олгосон тариалан чдын тоо. | гарал үүслийн гэрчилгээ олгосон. | олгосон байна. | - "Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүртгэл мэдээллийн plant.mofa.gov.mn цахим систем"-д 59.1га тариалангийн талбай бүхий 7 аж ахуйн нэгж, 13 иргэний бүртгэлийг баталгаажуулсан.<br>- Төмс, хүнсний ногооны цахим гарал үүслийн гэрчилгээг 25 иргэн, ААН-ийн 13 нэр төрлийн 120.6тн хүнсний ногоонд олгосон. | | |
| 5. | **Арга хэмжээ 1.5.** Дүүргийн нутаг дэвсгэр дэх хээлтэгч, хээлтүүлэгч малыг үзлэг ангилалтад хамруулах, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулна. | Зохион. байгуулса н арга хэмжээни й тоо | - | 2 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:<br>- Дүүргийн нутаг дэвсгэрт өндөр ашиг шимт цэвэр үүлдрийн үхэртэй эрчимжсэн аж ахуйн эрхлэгч 63 иргэний 1939 хээлтэгчийн судалгааг гаргасан.<br>- Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн "Хан-Уул дүүргийн мал бүхий 12,13,14 дүгээр хорооны өндөр ашиг шимт үүлдрийн болон сайжруулсан үхэр сүргийг ялган тэмдэглэж үзлэг ангилалт хийх ажлыг зохион байгуулах тухай" удирдамжийг батлуулж, цэвэр болон сайжруулсан үүлдрийн 621 үнээ, цэвэр үүлдрийн 13 бухыг ээмэгжүүлж, ялган тэмдэглэгээ хийх ажлыг зохион байгуулсан.<br>- Ялган тэмдэглэгээ хийж, бүртгэсэн бүртгэлийг Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн https://Livestock.mofa.gov.mn цахим системийн Ялган тэмдэглэсэн малын жагсаалтад малын төрөл, нас хүйс, малчин өрх тус бүрээр бүртгэж оруулсан. | 2025.08.30-2025.09.16 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | **Арга хэмжээ 1.7.** Малын нөхөн үйлдвэрлэл, үржил, селекцийг сайжруулж, эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 19 өрхийн 76 үхэрт зохиомол хээлтүүлэг хийгдсэн. | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | Малын нөхөн үйлдвэрлэл, үржил, селекцийг сайжруулж, эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд:<br>- Сүүний чиглэлийн үхэр сүргийн, үүлдэрлэг байдлыг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор "Монтаримал ХХК"-иас цэвэр үүлдрийн 3 хар тарлан худалдан авах ажлыг зохион байгуулж ажилласан.<br>- Сүүний үхрийн фермийн аж ахуй эрхлэгчдэд эрчимжсэн аж ахуйн стандарт, тугалын арчилгаа, маллагаа, тэжээллэг байдал, малын зохиомол хээлтүүлгийн ач холбогдлын талаар мэдээлэл зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулж, 4 өрхийн 67 үнээнд зохиомол хээлтүүлгийн ажил үйлчилгээг хийсэн. | 2025.01.02-2025.05.30 | 100% |
| **Зорилт 2. Хүнсний аюулгүй байдлыг хангах, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах хүрээнд** | | | | | | | |
| 7. | **Арга хэмжээ 2.1.** Газар тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор төмс, хүнсний ногооны худалдаа зохион байгуулж ажиллана. | Худалдаа зохион байгуулсан байршлын тоо, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ | 5 байршилд 30 газар тариалан эрхлэгчийн 97.2тн төмс, хүнсний ногоог худалдан борлуулж, 143.3сая төгрөгийн борлуулалт хийхэд | - | Дүүргийн хэмжээнд хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах, газар тариалан эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих зорилгоор төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдааг 3 байршилд зохион байгуулж нийт 28 ногоочин, 44.6 тн төмс, хүнсний ногоог худалдан борлуулахад дэмжлэг үзүүлэн, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан ажилласан. Мөн төмс, хүнсний ногооны гарал үүсэл, чанар аюулгүй байдалд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавин ажилласан. | 2025.08.25-2025.10.25 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дэмжлэг үзүүлсэн. | | | | |
| 8. | **Арга хэмжээ 2.2.** Малчин, мал бүхий иргэдийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангуулах ажлыг зохион байгуулж, дүүргийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Мал бүхий 12,13,14 дүгээр хорооны давхардсан тоогоор 1460 өрхөд 237.тн өвс, 66.9тн хивэг, 65тн улаан буудайн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсан. | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | Малчин, мал бүхий иргэдийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангуулах ажлын хүрээнд:<br>- Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн "Мал аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах ажлын удирдамж"-ийг 15 заалт бүхий "Бэлтгэл ажил хангуулах ажлын төлөвлөгөө" болон удирдамжийг батлуулсан.<br>- Дүүргийн хэмжээнд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 22тн өвс, 19тн тэжээл бэлтгэж, бэлэн байдлыг хангаж ажиллаж байна.<br>- Дүүргийн хэмжээнд өвөлжилтийн эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор зудын эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, эрсдэлийн үнэлгээ "Дунд" түвшинд үнэлэгдсэн.<br>- Онцгой байдлын хэлтэстэй хамтран Малчин өрхийн зудын гамшгийг даван туулах чадамжийн асуумж"-ийг нийт 339 малчин өрхөөс авч зөвлөгөө мэдээлэл өгөх уулзалтыг зохион байгуулсан. | 2025.01.02-2025.12.31 | 100% |
| 9. | **Арга хэмжээ 2.3** Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт хувь | Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна | Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:<br>- Дүүргийн Засаг даргын 2025 оны А/18 дугаар захирамжаар | 2025.01.02-2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулна. | | урьдчилан сэргийлэх 11 удаагийн дархлаажуулалтад давхардсан тоогоор 364,021 мал, амьтныг хамруулж, хяналт тавьж ажилласан. | | “Хязгаарлалтын дэглэм” тогтоож, 4 өрхийн нийт 91 үхрээс цус, сүүний дээжийг авч шинжлүүлэн, 5 үнээг хэрэгцээлүүлэх ажлыг зохион байгуулсан.<br>- Дүүргийн Засаг даргын 23 удаагийн захирамжаар импортоор оруулж ирсэн 1,777,000 үржлийн өндөг, 121 үржлийн адуунд хорио цээрийн дэглэм тогтоож, мал эмнэлгийн үзлэг шинжилгээнд хамруулж, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулж хяналт тавьж ажилласан.<br>- Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 12 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 303235 мал, амьтныг хамруулж, хяналт тавьж ажилласан.<br>- Мал амьтны шимэгчлэх өвчинтэй тэмцэх, эмчлэх, урьдчилан сэргийлэх, тархалт халдварлалтыг таслан зогсоох малд тарга тэвээрэг бүрэн авхуулах, малын гаралтай түүхий эдийн чанар, гарцыг сайжруулах зорилгоор 16800 малыг туулгалт, 13900 малыг угаалга, боловсруултанд хамруулсан.<br>- Дүүргийн нутаг дэвсгэрт зүй бусаар хорогдсон 743 ширхэг мал, амьтны сэг зэмийг устгаж, 612700 м2 талбай бүхий бэлчээрийн талбай, хашаа хороонд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж, хяналт тавьж ажилласан. | | |
| 10. | **Арга хэмжээ 2.4.** Мал амьтны гоц халдварт болон халдварт өвчнөөс | Зохион байгуулсан арга хэмжээни | 2023 оны мал, тэжээвэр амьтны | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, | Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан цахим системд: | 2025.01.02-2025.12.31 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх, малын шилжилт хөдөлгөөнийг хянах ажлын хүрээнд малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн баяжилтыг хийж, хяналт тавих ажлыг зохион байгуулна. | й тоо, цахим системд бүртгэгдсэн мал,амьтны тоо | тооллогоор тоологдсон 781 өрхийн 46919 мал, 631 төл, зүй бусаар хорогдсон 2050 мал, амьтныг мэдээллийн санд бүртгэсэн. | 2024 оны мал тооллоор тоологдсон 49463 малыг цахим системд бүртгэн баталгаажуулсан байна. | - 2024 оны мал, тэжээвэр амьтны тооллогоор тоологдсон 774 өрхийн 43990 мал,<br>- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 69 иргэн аж ахуйн нэгж,<br>- 2025 оны мал төллөлтөөр төллөсөн 5503 төл буюу 2493 бод, 2560 бог мал,<br>- Зүй бусаар хорогдсон 115 том малыг тус тус бүртгэн баталгаажуулсан.<br>- Цэвэр болон сайжруулсан үүлдрийн 621 үнээ, цэвэр үүлдрийн 13 бухыг ээмэгжүүлж, бүртгэсэн бүртгэлийг Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн https://Livestock.mofa.gov.mn цахим системийн Ялган тэмдэглэсэн малын жагсаалтад малын төрөл, нас хүйс, малчин өрх тус бүрээр бүртгэж оруулсан. | | |
| 11. | **Арга хэмжээ 2.5**<br>Мал амьтны хашаа хороо, бэлчээрийн ариутгалыг хийх, сэг зэм устгах ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3389 ширхэг мал, амьтны сэг зэмийг устгаж, 12000м2 талбай, 11000м2 талбай бүхий хашаа хороонд ариутгал халдваргүй | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/188 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, ариутгал халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулж, зүй бусаар хорогдсон 743 ширхэг мал, амьтны сэг зэмийг устгаж, 612700 м2 талбай бүхий бэлчээрийн талбай, хашаа хороонд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж, хяналт тавьж ажилласан. | 2025.04.30-2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | жүүлэлт хийсэн. | | | | |
| **Зорилт 3. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд** | | | | | | | |
| 12. | **Арга хэмжээ 3.1.** Цахим болон цаасан баримт бичгийг хүлээн авах, хуулийн хугацаанд шийдвэрлэх, албан хэрэг хөтлөлтийн талаарх бодлого стандарт журмыг хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах. | Албан бичгийн тоо, шийдвэрлэлтийн хувь | Дээд газар болон бусад байгууллагаас ирүүлсэн 183 албан бичгийг хүлээн авч 100% шийдвэрлэж, холбогдох хэлтэс албадад 106 албан бичиг боловсруулан хүргүүлсэн. | 100% | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын нэгдсэн erp.ulaanbaatar.mn системийн үйл ажиллагаагаар албан хэрэгцээндээ хэрэгжүүлж, 2025 оны жилийн эцсийн байдлаар:<br>- Дээд газар болон бусад байгууллагаас ирүүлсэн 217 албан бичгийг хүлээн авч 100% шийдвэрлэсэн.<br>- Дээд газар болон холбогдох хэлтэс албадад 71 албан бичиг боловсруулан хүргүүлсэн. | 2025.01.02-2025.12.31 | 100% |
| 13. | **Арга хэмжээ 3.2.** Иргэд, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээллийг судлан, хуулийн дагуу шийдвэрлэн хариу өгөх. | Өргөдөл гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь | Иргэдээс ирсэн 38 өргөдлийг хүлээн авч 100% шийдвэрлэсэн. | 100% | Иргэд, байгууллагаас ирсэн 65 өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээллийг судлан, хуулийн дагуу шийдвэрлэн хариу өгсөн. | 2025.01.02-2025.12.31 | 100% |
| 14. | **Арга хэмжээ 3.3.** Баримт бичгийг албан бичгийн стандартын дагуу зохион бүрдүүлэх, архивын стандартад | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан | 2-оос доошгүй хадгаламжийн нэгж үүсгэн, архивчид | 2024 оны батлагдсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан 3 хадгаламжийн нэгжийг архивын стандартын дагуу үүсгэж, хуваарийн | 2025.02.01-2025.03.25 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийцүүлэн байгууллагын архивд хадгаламжийн нэгжийг хүлээлгэн өгөх. | хүлээлгэн өгсөн баримтын тоо | 2 хадгаламжийн нэгжийг хүлээлгэн өгсөн. | хүлээлгэн өгсөн байна. | дагуу байгууллагын архивд хүлээлгэн өгсөн. | | |
| 15. | **Арга хэмжээ 3.4.** Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор баталсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ баримт бичгийн 2.8.2-т харилцаа, хандлага, хувцаслалт, биеэ авч явах байдал, ажлын арга барил, үг, үйлдлээрээ бусдад зөв үлгэрлэн, манлайлах. | Зөрчилтэй ажилласан эсэх | - | Харилцаа, хандлага, хувцаслалт, биеэ авч явах байдал, ажлын арга барил, үг, үйлдлээрээ бусдад зөв үлгэрлэн, манлайлж зөрчилгүй ажилласан байна. | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан 2 удаагийн сургалтад хамрагдаж, дүүргийн Засаг даргын 2025 оны "Төрийн албаны ёс зүй, сахилга, дэг журмыг сайжруулах тухай" 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 2025.01.02-2025.12.31 | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Худалдаа үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системд ирсэн хүсэлтийг хуулийн хугацаанд | Цахим системд бүртгэгдсэн иргэн, аж ахуйн нэгжийн тоо, | - | Хүсэлтийг шийдвэрлэсэн байна. | Худалдаа үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системд 2025 онд дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар нийт 369 иргэн, аж ахуйн нэгж хүсэлт ирүүлснийг магадлан шалгаж, 301 | 2025.02.12-2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрлэх ажлыг зохион байгуулах. | шийдвэрлэлтийн хувь | | | хүсэлт буюу 81.6 хувийг шийдвэрлэн ажилласан. | | |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.<br>Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг хүлээн авч, магадлан шалгаж, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах. | Хурал зохион байгуулсан тоо, шийдвэрлэлтийн хувь | - | Хүсэлтийг магадлан шалгаж, 100% шийдвэрлэсэн байна. | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/185 дугаар захирамжаар согтууруулах ундаа худалдах түгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн шинэчлэн баталж, ажлын хэсгийн хурлыг 23 удаа зохион байгуулж, согтууруулах ундаа үйлчлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн 144 аж ахуйн нэгжийн хүсэлтийг магадлан шалгаж, нийт 105 тусгай зөвшөөрлийг дүүргийн Засаг даргын захирамжаар олгож, улсын тэмдэгтийн хураамж 263.0 сая төгрөгийг дүүргийн төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнд:<br>- Спиртийн өндөр сул агууламжтай үйлчлэх тусгай зөвшөөрөл -93<br>- Спиртийн сул агууламжтай үйлчлэх тусгай зөвшөөрөл -12<br>- Хүчингүй болгосон -6<br>Нийслэл, дүүргийн Татварын хэлтэстэй хамтран тусгай зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн татварын өрийг барагдуулах зохион байгуулалтын ажил хийж, харьяа татварын хэлтсийн даргын өр хуваан төлөх хуваарь, тушаал, албан бичиг ирүүлсэн 44 аж ахуйн нэгжийн 827.7 сая төгрөгийн өрийг төлүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | 2025.02.12-2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Зөвшөөрөлгүй байршуулсан түргэн үйлчилгээний цэгийг нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулах. | Нүүлгэн шилжүүлсэн түргэн үйлчилгээний цэгийн тоо | 29 түргэн үйлчилгээний цэгийг нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлсөн. | Зөвшөөрөлгүй байршуулсан ТҮЦ-ийг нүүлгэн газар чөлөөлсөн байна. | Дүүргийн Засаг даргын 2025 оны “Газрын зөрчил арилгаж, албадан чөлөөлөх арга хэмжээ авах тухай” А/202 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд зөвшөөрөлгүй байршуулсан 310 түргэн үйлчилгээний цэгийг нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулан ажилласан. | 2025.03.19-2025.08.01 | 100% |
| 4 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Нөөцийн махны өргөтгөсөн худалдаанд хяналт тавьж ажилласан тухай. | Өргөтгөсөн худалдаа зохион байгуулсан тоо, хяналт тавьж ажилласан тоо | Нөөцийн махны худалдааг хүнсний дэлгүүр, сүлжээ 41 дэлгүүрээр 37.2 тонн, 28 удаагийн өргөтгөсөн худалдаагаар 172.1 тонн, нийт 209.3 тонн мах худалдаалах ажлыг зохион байгуулсан. | Хяналт тавьж ажилласан тоо | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн “Хүн амын стратегийн хүнсний нөөц бүрдүүлэх, хяналт тавих, худалдан борлуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2025 оны А/08 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нөөцийн махны 6 удаагийн өргөтгөсөн худалдаанд махны чанар аюулгүй байдалд хяналт тавьж, иргэдийн гомдол санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж ажилласан. | 2025.04.15-2025.05.30 | 100% |
| 5 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны газруудад хяналт тавьж ажилласан тухай. | | | | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/256 дугаар захирамжаар “Дүүргийн нутаг дэвсгэрт явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг, улирлын чанартай түр сүүдрэвчтэй худалдаа, үйлчилгээ эрхлэх байршлыг батлах, сонгон шалгаруулах ажлын хэсэг”-ийг шинэчлэн баталсан. | 2025.03.10-2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:<br>- Дүүргийн нутаг дэвсгэрт явуулын үйлчилгээтэй хоол үйлдвэрлэл эрхлэх боломжит 55 байршлын судалгааг гарган ажилласан.<br>- Туул гол дагуух явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэгийн стандартын шаардлага, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран 4 удаагийн хяналт шалгалт, 2 удаагийн газар чөлөөлөлт, 5 удаагийн уулзалтыг тус тус зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган, зөрчил дутагдлыг арилгуулан ажилласан.<br>- Мөн 3 удаагийн олон нийтийн арга хэмжээнд явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг эрхлэгч 10 иргэнийг оролцуулан, үйл ажиллагааг дэмжин, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад хяналт тавин ажилласан. | | |
| 6 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6.<br>"Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн нэгдсэн арга хэмжээнд худалдаа, үйлчилгээ зохион байгуулж, хяналт тавих тухай. | Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | 11 | Эрүүл ахуйн шаардлага хангасан худалдаа, үйлчилгээ гаргасан байна. | Дүүргийн "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн нэгдсэн арга хэмжээнд худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 22 иргэн, аж ахуйн нэгжийг оролцуулж, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан борлуулалтыг дэмжин, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаанд хяналт тавин ажилласан. | 2025.05.31-2025.06.01 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. Үндэсний их баяр наадмаар Төв цэнгэлдэх хүрээлэнд худалдаа үйлчилгээ зохион байгуулж, хяналт тавьж ажиллах. | Худалдаа, үйлчилгээ гаргасан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | Хоол үйлдвэрлэл үйлчилгээний шаардлага хангаж буй хоол үйлдвэрлэлийн 48 аж ахуйн нэгж, хүнсний худалдаа 8 иргэн, аж ахуйн нэгж, нийт 56 хүсэлтийг баталгаажуулан шийдвэрлэсэн. | 40-оос доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан байна. | Үндэсний их баяр наадмаар Төв цэнгэлдэх хүрээлэнд худалдаа үйлчилгээ эрхлэх хоол үйлдвэрлэл үйлчилгээний 33, хүнсний худалдааны 6, явуулын үйлчилгээтэй түргэн хоолны 4, нийт 43 иргэн аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгож, хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулан ажилласан. | 2025.07.01-2025.07.14 | 100% |
| 8 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8. Нийслэлийн "Иргэдийн баяр хүрээ цам даншиг" наадам"-д худалдаа, үйлчилгээ зохион байгуулж, хяналт тавьж ажиллах. | Худалдаа, үйлчилгээ гаргасан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | - | 10-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан байна. | Нийслэлийн "Иргэдийн баяр-хүрээ цам даншиг" наадмын үеэр Хүй долоон худагт худалдаа, үйлчилгээ эрхлэх 4, явуулын хоол үйлдвэрлэл 4, хоол үйлдвэрлэл үйлчилгээний 8 нийт 16 иргэн, аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгож, хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулан ажилласан. | 2025.06.23-28 | 100% |
| 9 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9. "Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг" зохион байгуулах. | Хамрагдсан төрийн байгууллагын тоо | - | Улсын үзлэгийг хугацаанд нь зохион байгуулсан байна. | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны "Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг явуулах тухай" А/442 дугаар захирамжаар байгуулагдсан Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн | 2025.10.13-21 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дарга Л.Отгонбаяраар ахлуулсан дүүргийн салбар комиссын доторх 5 дугаар ажлын хэсэгт нарийн бичгээр ажилласан.<br>Хороо, ОНӨААТҮГ, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг зэрэг нийт 18 байгууллагад төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг дүгнэх үзүүлэлт бүхий 3 чиглэлийн дагуу 2025 оны 10 дугаар сарын 13-21-ний өдрийг дуустал улсын үзлэг зохион байгуулсан. | | |
| 10 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 10.<br>Олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлын хэсэгт ажилласан тухай | Үйл ажиллагаан ы хэрэгжилт | - | Ажлын хэсэгт холбогдох мэдээ мэдээлли йг боловсру улж, хугацаанд нь өгсөн. | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны А/461 дүгээр захирамжаар батлагдсан Засаг даргын Тамгын газарт "Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015" олон улсын стандартыг нэвтрүүлэх үүрэг бүхий ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж, "Сонирхогч талын хэрэгцээ, хүлээлтийг тодорхойлох судалгаа","Стандартын процесс зураглал", "Үл тохирол бүртгэх, мэдээлэх, хяналт тавих журам" зэргийг боловсруулж, холбогдох мэдээ мэдээлэл зураглалыг гарган өгсөн. | 2025.09.19-2025.12.31 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Арга хэмжээ 1.**<br>Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан мэргэшүүлэх багц сургалтад хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо | Дээд шатны болон Тамгын газраас зохион байгуулсан 9 удаагийн сургалт, семинарт хамрагдсан | 4 | Дээд шатны болон Тамгын газраас зохион байгуулсан дотоодын 12, сертификаттай 1, гадаадын 1 нийт 14 сургалт, семинарт тус тус хамрагдсан. Үүнээс:<br>1. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны "Сургалтад хамруулах тухай" Б/140 тушаалаар АНУ-н Вашингтон хотын Потомакийн Их сургуулийн богино хугацааны "Гүйцэтгэх удирдлагын гэрчилгээний хөтөлбөр"-т хамрагдаж гэрчилгээ авсан.<br>2. Эрүүл монгол хүн үндэсний хөдөлгөөний “Зохистой хооллолт ба эрүүл мэнд” сертификаттай сургалт;<br>3. ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцооны стандартын дотоод аудитор бэлтгэх сургалт. | 2025.01.02-2025.12.31 | 100% |
| 2 | **Арга хэмжээ 2.**<br>Төрийн албаны тухай хуулийн 29.1-д заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдана. | Ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц | - | 1 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2025 оны | 2025.02.10-2025.06.16 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургалтад хамрагдсан байна. | | | 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай суралцаж төгссөн. | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХАРИУЦСАН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН .................................. / Б.НАРАНТУЯА/ 2025.12.05.

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХАРИУЦСАН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН БЯМБАДОРЖИЙН НАРАНТУЯАГИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр:Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнах, хяналт тавих хүрээнд** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 1.2. | 60 | 10 | 70 | |
| 3. | Арга хэмжээ 1.3. | 50 | 10 | 60 | |
| 4. | Арга хэмжээ 1.4. | 50 | 10 | 60 | |
| 5. | Арга хэмжээ 1.5. | 60 | 10 | 70 | |
| 6. | Арга хэмжээ 1.6. | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 2. Хүнсний аюулгүй байдлыг хангах, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах хүрээнд** | | | | | |
| 7. | Арга хэмжээ 2.1. | 60 | 10 | 70 | |
| 8. | Арга хэмжээ 2.2. | 50 | 10 | 60 | |
| 9. | Арга хэмжээ 2.3. | 60 | 10 | 70 | |
| 10. | Арга хэмжээ 2.4. | 60 | 10 | 70 | |
| 11. | Арга хэмжээ 2.5. | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 3. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд** | | | | | |
| 12. | Арга хэмжээ 3.1. | 60 | 10 | 70 | |
| 13. | Арга хэмжээ 3.2. | 60 | 10 | 70 | |
| 14. | Арга хэмжээ 3.3. | 60 | 10 | 70 | |
| 15. | Арга хэмжээ 3.4. | 60 | 10 | 70 | |
| **Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт** | | | | | |
| 16. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.** | 60 | 10 | 70 | |
| 17. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.** | 60 | 10 | 70 | |
| 18. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.** | 60 | 10 | 70 | |
| 19. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4.** | 60 | 10 | 70 | |
| 20. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5.** | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 21. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6.** | 60 | 10 | 70 | |
| 22. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7.** | 60 | 10 | 70 | |
| 23. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8.** | 60 | 10 | 70 | |
| 24. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9.** | 60 | 10 | 70 | |
| 25. | **Үүрэг даалгавар (арга хэмжээ) 10.** | 60 | 10 | 70 | |
| **Дундаж оноо:** | | | | 68.8 | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1. | 100% | 15 | |
| 2. | Арга хэмжээ 2. | 100% | 15 | |
| **Дундаж оноо** | | | 15 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| **Дундаж оноо** | | 6,8 | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 7,5 |
| 3. | Харилцаа | 7,75 |
| **Дундаж оноо** | | 7,75 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | 68,8 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | 6,8 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 7,75 |

| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | (..... оноо)<br>93 |
|---|---|---|
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 98,37 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга ............................ /Л.Саруултуяа/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.12.05
*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Хүнс, хөдөө аж ахуй хариуцсан хэлтсийн ахлах мэргэжилтэн ............................ /Б.Нарантуяа/
2025.12.05
*(огноо)*

***Үнэлгээг хянасан:***
*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ............................ /О.Мөнгөншагай/
2025.12.15
*(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*
Хүний нөөц, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан ахлах мэргэжилтэн ............................ /Б.Саранцацрал/
2025.12.15
*(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***
Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ............................ /З.Буянт/
2025.12.15
*(огноо)*